

**АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ
ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ БУУЛГАН ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА**

Дархан-Уул аймгийн Дархан Дахин Төлөвлөлт ОНӨААТҮГазраас Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, БХБСайдын 2016 оны 126 дугаар тушаал “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам, БХБСайдын 2016 оны 84 дугаар тушаал “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх талбай сонгох үлгэрчилсэн журам”, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 98 дугаар тогтоол, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/198 тоот захирамжийг тус тус үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих байршилд төсөл хэрэгжүүлэх тухай битүүмжилсэн баримт бичгийг ирүүлэх сонгон шалгаруулалтад урьж байна.

№	БАГЦ	БАЙРШИЛ
1	ДАУ_ДС4-200Е	Дархан сумын 4 дугаар багийн нутаг дэвсгэрт "Е" хэсэгчилсэн талбай, нийт 0.2 га
1	ДАУ_ДС5-200В	Дархан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт "В" хэсэгчилсэн талбай, нийт 7.5 га

Нэг. Төсөл хэрэгжүүлэхийг сонирхож буй этгээд нь шалгаруулалтад оролцож, урилгад заагдсан төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын баримт бичгийг авах хүсэлтээ бичгээр ирүүлэх ба эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 300,000 (гурван зуун мянган) төгрөгийг доорх дансанд тушааж төлбөрийн баримтыг хавсаргасан байна.

Төлбөрийн данс: Худалдаа Хөгжлийн Банк: **Дархан Дахин Төлөвлөлт ОНӨААТҮГ 403182004** тоот дансанд

Гүйлгээний утга: Компанийн нэр, төслийн баримт бичгийн нэр, багцын дугаар

Хоёр. Урилгын дагуу төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын баримт бичгийг худалдан авч танилцсан этгээд төсөл хэрэгжүүлэх саналаа зааврын дагуу бэлдэж битүүмжилсэн байдлаар эх хувь, цахим хувийг бэлтгэн **2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 10:00 - 15:00 цагийн хооронд** Дархан Дахин Төлөвлөлт ОНӨААТҮГазар /6 дугаар багийн төв” 3 давхар 10 тоотод/ хүлээлгэн өгнө. Тус өдрийн 17 цагт сонирхогчдод оролцогчдын мэдээллийг нээлттэй зарлана.

Гурав. Оролцогчийн санал гаргагч нь сонгон шалгаруулалтын баримт бичигт тусгагдсан болон дор дурдсан нийтлэг материалуудыг бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбар, байгууллагын ерөнхий танилцуулга
2. 2022, 2023 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
3. Татвар, нийгмийн даатгал, банкны тодорхойлолт. Бүх шатны шүүхийн маргаангүй /шүүхийн архивын лавлагаа/ болон Шийдвэр гүйцэтгэлийн албаны тодорхойлолт.
4. Гэрээ /Түншлэлийн хувьд талууд хамтран ажиллахаа илэрхийлсэн түншлэлийн гэрээ эсхүл барилга угсралт, зураг төсөл зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх, хамтран ажиллах, туслан гүйцэтгэх гэрээ, гадаадын хөрөнгө оруулагчтай түншлэлийн

гэрээ байгуулсан байж болно/

5. Төсөл хэрэгжүүлэх хөтөлбөр, аргачлал, технологийн шийдлийг тусгасан төлөвлөгөө.
6. Сараар, жилээр гаргасан үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний хамт
 - a. Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө
 - b. Иргэдтэй уулзах, иргэдийн саналыг төсөлд тусгах төлөвлөгөө
 - c. Газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, нөхөн олговор, эзэмшигчийг нүүлгэх, түр суурьшуулах, талбайг чөлөөлөх төлөвлөгөө.
 - d. Төслийн тайлан, төслийг хаах үйл ажиллагааны төлөвлөгөө
7. Сүүлийн 3 жилд хийж гүйцэтгэсэн зураг төслийн болон барилга угсралтын ажлын туршлага.
8. Санхүүгийн эх үүсвэр /төсөлд шаардагдах нийт хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нотолсон дансны хуулга, зээлжих эрх, банкны баталгаа/
9. Бүх бичиг баримт монгол хэл дээр байх бөгөөд хэрэв гадаад хэл дээр материал хавсаргах бол баталгаат орчуулгаар орчуулсан байна.

ТӨСЛИЙН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ:

Хаяг: Монгол улс, Дархан-Уул аймаг, Дархан сум, Ханжаргалант гудамж, 6-р баг, Төрийн үйлчилгээний төвийн 3 давхар

Утас: 95801408

Вэб сайт: www.ddt.gov.mn

ЭДЭЛБЭР ГАЗРЫН БАЙРШЛЫН СХЕМ

Байршил	Газрын зориулалт	Талбайн хэмжээ
Дархан сум 4 дугаар баг	Ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг буулган шинээр барих /"Е" хэсэгчилсэн талбай/	0.22 га

ДАРХАН ДЭЭД
СУРГУУЛЬ



Таних тэмдэг

- Төслийн талбай /Ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг буулган шинээр барих хил хязгаар/
- Төсөл хэрэгжиж буй талбай

ЭДЭЛБЭР ГАЗРЫН БАЙРШЛЫН СХЕМ

Байршил	Газрын зориулалт	Талбайн хэмжээ
Дархан сум 5 дугаар баг	Ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг буулган шинээр барих /"В" хэсэгчилсэн талбай/	7.5 га

ХҮСЛЭН
ТӨВ



Таних тэмдэг

- "В" Хэсэгчилсэн талбай /Ашиглалтын шаардлага хангахгүй барилга, байгууламжийг буулган шинээр барих хил хязгаар/
- Дараачийн ээлжинд төсөл хэрэгжүүлэх талбай